

БҮТЭЭГЧ БУРХАНЫГ МЭДЭЦГЭЭ

Үеүдийн Хаан,
үхэшгүй,үл үзэгдэх
цорын ганц Бурханд
хүндлэл ба алдар нь
үеийн үед байх
болтугай. Амен.
(1 Тим 1:17 АБ 2004)

Израиль аа, сонс!
ЭЗЭН бол бидний
Бурхан, ЭЗЭН бол
ганц.
(Дэд хууль 6:4 АБ 2004)

Есүс
-Эхнийх нь “Сонс,
Израиль аа! Бидний
Бурхан Эзэн бол ганц
Эзэн мөн.
(Марк 12:29 АБ 2004)

7. ААВ БУРХАН

7.1 БУРХАН БОЛ ХАЙР

"Бурхан бол хайр; Түүний зарлигууд нь хайрын улмаас өгөгдсөн" гэдгийг бүх өнцгөөс суралцаж, тунгаан бод. Түүний шүүлтүүд үнэн ба шударга бөгөөд дуулгавартай байх хүсэлтэй хэн бүхэнд сургамж болдог.

Бурхан бузар мууг үзэн ядаж, хүүхдүүдээ ерөөхийг хүсдэг ч бид Түүний үгэн дэхь ерөөлийн зам дээр ажиллах ёстой. Бузар муу ба өвлөн авсан хараал нь Бурханы хүслийн эсрэг махан биеийн хүсэл, сэтгэлийн хүсэлд автуулдаг. Хүүхдийг Бурханы үгэн дотор эрэлхэг зоригтой хүн болгон төлөвшүүлэхгүй л бол бүх нүгэлтнүүд бие бие рүүгээ хуруугаараа чичдэг.

Үгийг хайрлаж, Түүний сургаалийг хүлээж, өглөө бүр түүнийг бясалга. Орой бүр зүрх сэтгэлээсээ эргэцүүлэн, сонс.

Дахин унш. Нэг суухдаа 10 удаа унших шаардлагатай байсан ч Сүнсний зааж буй зүйлийг сонсох хүртлээ бүү зогсоорой. Тэр чиний дотор байгаа бөгөөд Тэр чамд заана гэдэгт итгээрэй. Түүнийг мэдлэг, туршлагаараа бүү хязгаарлаарай. Ирээдүй бол Эзэнийх юм.

¹⁶Үргэлж баяртай бай. ¹⁷Тасралтгүй залбир. ¹⁸Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн (1 Тес 5:16-18 АБ 2004)

Би чиний явах ёстой замд чамд зааварлан зааж өгнө.
Би чамайг ширтэн, чамд зөвлөнө. (Дуу 32:8 АБ 2004)

- [] Та хайр гэж юу болохыг мэдэх үү?
- [] Танд хайртай хүн бий юу?
- [] Таньд хайрлах ёстой хүн бий юу?
- [] Бурханы хайр гэж юу болохыг та мэдэх үү?
- [] Бурханы хайр юу хийснийг та мэдэх үү?
- [] Бурханы хайр юу хийж байгааг та мэдэх үү?
- [] Бурханы хайр юу хийдгийг та мэдэх үү?

Би бол амьд мөнхийн Бурхан гэж ЭЗЭН тунхаглаж байна
Би бол удахгүй ирэх Бурхан
Миний үгэнд хайхрамжгүй, хайнга хандах хэрэггүй
Миний үгийг үл тоомсорлож болохгүй

Миний үгийг сахидаг
Миний зааврыг дагадаг
Уншиж, бясалгадаг
Бичигдсэнчлэн хийдэг хүмүүст би хайртай

Би бүх зүйлийг Өөрийнхөө цагт хийдэг
Мөн миний цаг бол зөв цаг юм.
Би хэлсэн бүхнээ, хэлснийхээ дагуу хийдэг
Миний хийж байгаа зүйл төгс бөгөөд зөв

Би шинэ тэнгэр, шинэ газарыг бүтээх болно
Минийхийг эсэргүүцэж байгаа бусад бүх төлөвлөгөөний эсрэг
Миний төлөвлөгөө бат зогсдог

Гэмшигтүн!

7.2 БҮТЭЭГЧ БУРХАН

7.2.1 ТЭНГЭР, ГАЗАР

¹Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ. ²Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр нь харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа.

³Тэгээд Бурхан-Гэрэл бий болог! гэсэнд гэрэл бий болов. ⁴Бурханыг харахад тэр гэрэл нь сайхан байв. Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ.

⁵Бурхан гэрлийг өдөр, харанхуйг шөнө хэмээн нэрлэжээ. Үдэш болоод, өглөө болжээ. Тэр нь анхны өдөр болой. (Эхл 1:1-5 АБ 2004)

²¹Та нар мэдэхгүй гэж үү?

Та нар сонсоогүй гэж үү?

Эхнээсээ та нарт үүнийг зарлаагүй гэж үү?

Дэлхийн сууриас та нар ойлгоогүй юу?

²²Царцаанууд шиг оршин суугчидтай дэлхийн тойрог дээр залрагч нь Тэр билээ.

Тэр тэнгэрийг хөшиг мэт татаж,
майхан мэт дэлгэн оршдог.

²³Тэр захирагчдыг юу ч биш болгон,
газрын шүүгчдийг хэрэггүй болгоно.

²⁴Тэднийг дөнгөж таригдаад, үрслэгдээд,
үндэс нь газарт үндэслэмэгц,

Тэр тэдэн уруу үлээдэг.

Тэд хатаж, сүрэл мэт шуурганд хийснэ. Та мэдэхгүй байна уу?
(Иса 40:21-24 АБ 2004)

²⁵“Тэгвэл та нар Намайг хэнтэй адилтгаж,
хэнтэй тэнцүүлэх вэ?” гэж Ариун Нэгэн айлдаж байна.

²⁶Нүдээ өндөрт өргөн тэдгээрийг хэн бүтээснийг харагтун.
Тэдгээр оддын эздийг тоогоор нь авчрагч Нэгэн тэднийг
бүгдийг нь нэрээр нь дууддаг юм.

Түүний агуу их хүч, сүр жавхлангийн улмаас тэдгээрээс нэг
нь ч алдагдаагүй. ²⁷“Миний зам ЭЗЭНээс нуугдаж,
үйлсийг минь миний Бурхан мартсан” гэж чи яагаад өгүүлнэ
вэ, Иаков оо?

Чи юунд ярина вэ, Израиль аа?

²⁸Чи мэдэхгүй гэж үү?

Чи сонсоогүй гэж үү?

Мөнхийн Бурхан болох ЭЗЭН дэлхийн хязгаарыг Бүтээгч нь эцэж туйлддаггүй юм.

Түүний ухаан нь хязгааргүй.

²⁹Тэр ядарсанд тэнхээ өгч,
чадал дутагдсанд нь хүч нэмдэг.

³⁰Залуу хүн ч ядарч сульдан,
идэр хөвгүүд ч бүдэрдэг.

³¹Харин ЭЗЭНд найдагчдын хүч нь шинэчлэгдэнэ.

Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина.

Тэд гүйхдээ үл ядран,

алхахдаа үл цуцна. (Иса 40:25-31 АБ 2004)

¹²Намайг сонсогтун, Иаков оо. Миний дуудсан Израиль аа.

Би бол Тэр мөн.

Би бол эхэн бөгөөд Би бас эцэс мөн.

¹³Миний мутар газрыг үндэслэн,

Миний баруун мутар тэнгэрийг дэлгэв.

Би тэднийг дуудахад тэд хамтдаа зогсдог. (Иса 48:12-13 АБ 2004)

[] Бурхан тэнгэр газрыг бүтээсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Тэрээр бүтээсэн бүхнийхээ эзэмшигч нь гэдэгт та итгэдэг үү?

[] Тэрээр бичигдсэнчлэн бүгдийг биелүүлдэг гэдэгт та итгэдэг үү?

[] Түүнд бүхнийн захирах хүч чадал “Есүсийн хүчирхэг нэрний”

хүч байдаг гэдэгт та итгэдэг үү?

[] Бүх худал бурхад ба тэдний дагалдагчидад төгсгөл ирнэ гэдэгт та итгэдэг үү?

7.2.2 ТҮҮНИЙ МЭЛМИЙД САЙН САЙХНЫГ БҮТЭЭСЭН

Аливаа зүйл бүтээснийхээ дагуу байхдаа хэвийн бөгөөд ямар нэгэн сайжруулалт хэрэггүй байдаг. Түүний бүтээсэн зүйл нь сайн: "Хэвийн"

Хэвийн мөн чанар: Бурхан бүгдийг бүтээсэн бөгөөд энэ нь сайн. Хэвийн гэдэг нь Түүний мэлмийд сайн гэсэн утгатай юм

⁶Бурхан

-Усан дотор огторгуй бий болж, усыг уснаас салгаг! гэж айлдав. ⁷Тийнхүү Бурхан огторгуйг бий болгоод, огторгуйн дээрх усыг огторгуйн доорх уснаас салгасанд тэр нь ёсоор болов. ⁸Бурхан огторгуйг тэнгэр гэж нэрлэжээ. Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь хоёр дахь өдөр бөлгөө.

Бурхан -Тэнгэрийн доорх ус нэг дор хуримтлагдаж, хуурай газар ил гараг! хэмээсэнд тэр нь ёсоор болжээ.¹⁰Бурхан хуурай газрыг эх газар, хуримтлагдсан усыг далай хэмээн нэрлэв. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. ¹¹Тэгээд Бурхан -Газар дэлхий нялх ногоо, үрт ургамал, үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулаг! гэсэнд тэр нь ёсоор болжээ. ¹²Газар дэлхий нялх ногоо, үрт ургамал, үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулав. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. ¹³Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь гурав дахь өдөр болой.

¹⁴Тэгээд Бурхан -Өдрийг шөнөөс салгахын тулд огторгуйд гэрэлтүүлэгчид бий болог. Эдгээрээр тэмдэг, улирал, өдөр, жилүүд бий болог. ¹⁵Тэнгэр огторгуйд гэрэлтүүлэгчид байж, газар дэлхийг гийгүүлэг гэсэнд тэр нь ёсоор болжээ. ¹⁶Бурхан илүү том нь өдрийг, арай жижиг нь шөнийг захирч байхаар хоёр том гэрэлтүүлэгчийг бүтээв. Тэр бас оддыг бүтээлээ. ¹⁷Бурхан газар дэлхийг гэрэлтүүлэхийн тулд, мөн ¹⁸өдөр, шөнө хоёрыг захирахын тулд болон гэрлийг харанхуйгаас салгахын тулд тэднийг тэнгэр огторгуйд байрлуулав. ¹⁹Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь дөрөв дэх өдөр болой.

²⁰Бурхан -Уснууд амьтдаар дүүрч, жигүүртэн шувууд газар дэлхий дээгүүр, тэнгэр огторгуйгаар нисэг гэв. ²¹Тэгээд Бурхан далай тэнгисийн аварга том амьтад хийгээд усаар дүүрэн үржин амьдардаг, хөлхөн хөдлөгч аливаа амьтдыг төрөл төрлөөр нь бүтээв. Бас аливаа жигүүртэн шувуудыг төрөл төрлөөр нь бүтээв. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. ²²Бурхан тэднийг адислаж, -Өсөн төлжиж, үржин олширч, далай тэнгисийн усыг дүүргэ. Бас жигүүртэн шувууд газар дэлхийд өсөн үржиг хэмээв. ²³Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь тав дахь өдөр болой.

²⁴Бурхан -Газар дэлхий амьтдыг төрөл төрлөөр нь буюу мал адгуус, мөлхөгчид, газрын зэрлэг араатныг төрөл төрлөөр нь бий болгог хэмээн айлдав. Тэр нь ёсоор болжээ.

(Эхлэл 1:6-24 АБ 2004)

³¹Бурхан Өөрийнхөө бүтээсэн бүгдийг харахад нэн сайхан байжээ. Үдэш болоод, өглөө болов. Тэр нь зургаа дахь өдөр болой. (Эхлэл 1:31 АБ 2004)

[] Бүх зүйлийг ҮГ бүтээсэн гэдгийг та мэдэх үү?

[] Дайсан Үгийг хэрхэн, яагаад гуйвуулдгийг та мэдэх үү?

[] Байгаль дэлхий Түүний хүүхдүүдэд төгс тэнцвэртэй байхаар бүтээгдсэн. Энэ тэнцвэрийг юу эвддэгийг та мэдэх үү?

[] Тушаалын адислалуудаа бүтээлээс буцааж аваагүй гэдэгт та итгэдэг үү?

7.3 ХЭВИЙН ГЭДЭГ НЬ ТҮҮНИЙ МЭЛМИЙД САЙХАН ХАРАГДАХ ГЭСЭН УТГАТАЙ

ЭЗЭНий өмнө юу нь зөв, сайн болохыг үйлд. Тэгвэл чи сайн сайхан байж, чиний өвөг дээдэст ЭЗЭНий тангарагласан тэр сайхан газар нутагт очин, эзэмшинэ.

(Дэд хууль 6:18 АБ 2004)

[] « Сайн ажил » гэж юу вэ?

[] Та Түүний мэлмийд сайн гэж тооцогдох зүйлийг хийж байна уу?

7.4 ХЭВИЙН ГЭЖ ЮУ БОЛОХЫГ МЭДЭХ

Их Эзэнээс ирэх "ач ивээл дор хийгээд амар амгаланд" хэвийн амьдрал оршиж байдаг.

а) Энэ нь Түүний мэлмийд сайхан харагддаг.

б) Энэ нь тэнцвэртэй, зүүн тийш ч, баруун тийш ч хазайдаггүй бөгөөд адислалын хил хязгаар дотор байдаг. Энэ тэнцвэртэй амьдрал нь хүч авчирдаг. Та нарын сүнс тэнцвэртэй байвал сүрдмээр хүч авч ирнэ.

в) Тэнцвэртэй байх гэдэг нь Түүний оршихуйд алхах, Түүний хүслийг мэдэх, хэзээ үйлдэл хийх хэрэгтэй гэдгээ мэдэх явдал юм.

г) Та тэнцвэрээ алдсан үед Түүний үгнээс гадуур байж, хараалын дор байж нүгэлд захирагдана.

д) Зүүн ч, баруун тийш ч эргэж болохгүй. Хэтрүүлж болохгүй, дутуу хийхгүй байх.

е) Зорилгодоо хүрэхийн тулд сахилга баттай байж, оюун ухаанаа хянаж, чадах бүхнээ хийх нь сайн. Гэхдээ гажуудуулах, буулт хийх, эсвэл зарчмуудыг өөрчлөх замаар зорилгодоо хүрэх гэх нь буруу.

ё) Хэвийн бус бүхнээс татгалзах, зогсоох, орхих

ж) Хэвийн хөрөнгө оруулалт нь ерөөл боловч гажуудуулах нь буруу.

з) ҮНВН, ЭЗЭН-тэй Бурханы бичсэн зам- хэвийн аргаар уулз. Ялангуяа, сүнслэг сургалтанд.

ж) Израиль нь тогтоогдсон баяр наадмаар дамжуулан амьд Бурхантай уулзсан: Түүний цагт, Түүний арга замаар

к) Израиль Есүс Христээр дамжуулан амьд үгтэй нүүр тулан, харц тулгаран уулзсан.

л) Өнөөдөр бид үнэнээр, сүнсээрээ мөргөх замаар Ариун Сүнсээр дамжуулан Бурхантай уулздаг

м) Та хэвийн хүн болсноор амьдралдаа амьд үгийг мэдэрч гэрчлэлийн амьдралаар амьдарна.

7.5 ХЭВИЙН ХҮН БАЙХ

а) Хэрэв та гэрлэсэн боловч өөр хүнд дурлавал гэр бүл хэврэгшиж, хэвийн бус болно. Та хоёр хүнд хайртай болбол оюун ухаан тань хуваагдаж, бүрэн хайрлуулах боломжгүй болдог. Бурхан ч мөн адил нэг зүрх, нэг оюун ухаан Түүн дээр бүрэн төвлөрүүлсэн хүмүүст баярладаг. Тэр хүний төлөө Тэрээр ивээл ерөөлийн бүрэн дүүрэн хаалгыг нээдэг.

б) Хувийн ашиг сонирхлын төлөө бус Өөрөөс нь эмээдэг шаргуу, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан хайж байна.

в) Түүний дотор тэнцвэртэй амьдрах гэдэг нь та Түүний хүслийн дагуу, Түүний замаар замнаж, Түүний цаг хугацаанд амьдрахыг хэлнэ. Иймээс та Түүний хамгаалалт, хангалт, хүчний дор байна. Та төөрч, тэнцвэрээс гадуур үед хил хязгаараас гадна байж өөрт зөв мэт санагдсан зүйлийг үйлдэнэ.

г) Иаков болон түүний ээж Ребека Бурханы төлөвлөгөөг Иаковын амьдралаар биелүүлэхийг хичээсэн. Гэсэн хэдий ч тэд Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд хэвийн бус арга зам сонгосон учраас тэд асар их төлөөс төлсөн.

д) Хэвийн хүүхэд өдөр бүр залбирлаар дамжуулан Бурхантай уулзах ёстой

Их Эзэний Сүнстэй уулзах чин хүсэлдээ хөтлөгдөх үед тэр хүүхэд амьд Бурханы ажиллагааг мэдэх болно.

е) Та Түүнтэй хэр олон удаа уулздаг вэ? Цөхөрсөн үедээ л үү? Хайртай хүмүүстэйгээ та хэр ойр ойрхон уулздаг вэ?